



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/93

Халбан

Мал угаалгын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд мал угаалгын ажлыг сумын хэмжээнд 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг "Баялаг үйл- Ундрах" мал эмнэлгийн захирал, малын эмч (М.Баатаржав), "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн захирал, малын эмч (Н.Доржжүгдэр), бусад гэрээт малын эмч, мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

2. Мал угаалгын ажлыг гүйцэтгэхдээ мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, уг хуулийг дагалдан гарсан журам, заавар бусад эрх зүйн баримт бичгүүд, малаа угаалганд бүрэн хамруулахын ач холбогдол зэргийг малчид, иргэдэд сайтар сурталчилан хэрэгжүүлж ажиллахыг гэрээт мал эмнэлгийн нэгжийн эмч мэргэжилтнүүдэд даалгасугай.

3. Мал угаалгын ажил гүйцэтгэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн хяналтын Улсын Байцаагч (Н.Алтанхуяг)- д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АЛТАНХУЯГ



Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 22-ны өдрийн А/93
дугаар захирамжийн хавсралт

**МАЛ УГААЛГЫН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго: Мал сүргийн шимэгчтэх өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, МЭЕГ, Аймгийн МЭГ- аас ирүүлсэн албан даалгавар, зөвлөмж, үүрэг чиглэл, оны эхэнд мал эмнэлгийн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах.

Хоёр. Хугацаа: Мал угаалгын арга хэмжээг 2024 оны 07 сарын 22-ны өдрөөс 08 сарын 15-ны хугацаанд хийж гүйцэтгэнэ. Малчид, мал бүхий иргэдийн хүсэлтээр намар 09 сард давтан угаалга хийж болно.

Гурав. Хамрах хүрээ , арга хэрэгсэл: Мал эмнэлгийн нэгжийн эмч мэргэжилтнүүд нь гэрээт баг, өрхүүдийн бод малын 80- с доошгүй хувийг шүрших аргаар угаалганд хамруулна. Бог малыг угаалганд 100 хувь хамруулан шүрших, шумбуулах аргыг хослуулан хэрэглэнэ. Боломжит бүх арга хэрэгсэлийг ашиглана.

Дөрөв. Бусад зохион байгуулалтын ажлын талаар: Угаалга хийх эмийн бодисоо зөв сонгон хэрэглэж ажил үйлчилгээний нэг цэгийн хашаа, зөөврийн төмөр хашаа, суурин ванн, "ДУК" автомашин зэрэг бүх арга хэрэгсэлийг үр дүнтэй ашиглан малчдын хүч нөөцийг төвлөрүүлж зөв зохион байгуулж ажиллана. Гэрээт мал эмнэлгийн эмч мэргэжилтнүүд нь мал угаалгын ажлыг багийн засаг даргатайгаа хамтран богино хугацаанд үр дүнтэй гүйцэтгэнэ.

Мал угаалгын гүйцэтгэлийг МЭНС-д тухай бүр оруулж өдөрт нь системд илгээж МЭТ-т утсаар өдөр тутмын мэдээг өгч ажиллана.

Мал угаалгын ванны засвар үйлчилгээ, "ДУК" автомашины зардал, мотор, мотопомпо, тээвэр шатахуун, эм бэлдмэлийн зардал зэргийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд өөрсдөө хариуцаж ажил гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар журмыг чанд мөрдөж ажиллана.

Тав. Ажил дүгнэх: Гэрээт мал эмнэлгийн нэгжийн малын эмч мэргэжилтнүүд нь мал угаалгын ажил зохион байгуулсан тухай явцын тайлан мэдээгээ долоо хоногт 2 удаа мал эмнэлгийн тасагт өгөгдсөн маягтаар өгч эцсийн мэдээг 2024 оны 08 дугаар сарын 20-нд ирүүлнэ. Тайлан эцэслэн гаргахдаа үнэн зөв, цэвэр, засваргүй хийж зурган мэдээллээр баталгаажуулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН МЭТ-ИЙН МЭХУ-ЫН
БАЙЦААГЧ ЭМЧ *Н. Алтанхуяг* Н. АЛТАНХУЯГ